



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 703

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 52,081,354.50 (тавин хоёр сая наян нэгэн мянга гурван зуун тавин дөрвөн төгрөг тавин мөнгө) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэр газрын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэр газрын захирал (Г.Гансүх)-д Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай;

3. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэр газрын захирал (Г.Гансүх)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай

3.1. Үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн тухайн жилийн бизнес төлөвлөгөөг боловсруулж ажиллах;

3.2. Байгууллагын хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журмыг салбарын хамтын гэрээ, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, цаашид байгууллагын дотоодод мөрдөх эрх зүйн баримт бичгийн хоорондын уялдааг ханган боловсруулж мөрдүүлэн ажиллах;

3.3. Ажилчдад ээлжийн амралтын урьдчилгаа хэлбэрээр зээл олгохыг таслан зогсоох;

3.4. Батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх.

4. Тогтоолын биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 13 -ны өдрийн
703 дугаар тогтоолын хавсралт



“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн
газарт хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил,
дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Ажилчдад ээлжийн амралтын урьдчилгаа хэлбэрээр зээл олгосон	38,605,000.0	Төсвийн тухай хууль, Хэмнэлтийн тухай хууль	Төсвийг зориулалтын дагуу зарцуулах
2	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	13,476,354.5	ТБОНӨТ хуулийн 11.8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 558 дугаар тогтоол	Хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөнд тусгаагүй хөрөнгө бэлтгэхгүй байх
НИЙТ ДҮН:		52,081,354.50 (тавин хоёр сая наян нэгэн мянга гурван зуун тавин дөрвөн төгрөг тавин мөнгө)		